


**ЭМНЭЛГИЙН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС
ЗҮЙН САЛБАР ХОРОО, ЭМНЭЛГИЙН ЗАХИРГААТАЙ ХАМТРАН
2025 ОНЫ ЭХНИЙ 5 САРД ЗОХИОН БАЙГУУЛСАН
СУРГАЛТУУД**

1. 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр (лхагва гариг) өглөө 08.00 цагт эмнэлгийн 4-р давхрын хурлын их танхимд нийт эмч нарт Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эрдмийн сургуулийн Анагаах ухааны эрх зүй, боловсрол судлалын тэнхимийн профессор, Анагаах ухааны доктор, профессор Н.Сүмбэрзултай хамтран “Манлайлал, түүний хэлбэрүүд” сэдэвт сургалтын зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явцаас

2. 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 16.00 цагт эмнэлгийн 4-р давхрын хурлын их танхимд нийт сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд Компанийн засаглал судлаач, Хүний нөөцийн үндэсний хүрээлэнгийн сургагч багш, хуульч Н.Цогжавхлантай хамтран “Шинэ цагийн сувилагчийн манлайлал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Шинэ цагийн сувилагчийн манлайлал сэдэвт сургалтын явцаас

3. 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр (лхагва гариг) өглөө 08.00 цагт эмнэлгийн 4-р давхрын хурлын их танхимд нийт эмч нарт Хүний эрхийн үндэсний комиссын ахлах мэргэжилтэн, Хууль зүйн ухааны доктор, Цагдаагийн хурандаа Д.Нямдоржтой хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль сэдэвт сургалтыг зохион байгуулсан.





Зураг. Сургалтын явцаас

4. 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр (Пүрэв гариг) өглөө 08.00 цагт эмнэлгийн 4-р давхрын хурлын их танхимд суралцагч эмч нарт Компанийн засаглал судлаач, хүний нөөцийн үндэсний хүрээлэнгийн сургагч багш, хуульч Н.Цогжавхлантай хамтран “Эерэг хандлага, бүтээлч сэтгэлгээ” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Суралцагч эмч нарын сургалтын явцаас

5. 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж удирдлагуудад лектор Д.Мягмардорж “Манлайллын далд хүчин зүйлс”, “Шинэ ажилтныг дасан зохицуулах хөтөлбөр” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.




Зураг. Сургалтын явцаас

6. 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр (лхагва гариг) өглөө 08.00 цагт эмнэлгийн 4-р давхрын хурлын их танхимд нийт эмч нарт Компанийн засаглал судлаач, хүний нөөцийн үндэсний хүрээлэнгийн сургагч багш, хуульч Н.Цогжавхлантай “Шинэ цагийн эмчийн манлайлал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явцаас

7. Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь Сүхбаатар дүүргийн прокурорын газартай 2023.05.15-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээтэй болно. Хамтын ажиллагааны дагуу Прокурорын газрын хяналтын прокурор Б.Энхзултай хамтран Эрчимт эмчилгээний тасагт хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн үл тохирол дахин гарахаас урьдчилан сэргийлж 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Эрчимт эмчилгээний тасгийн нийт ажилтнуудад “Хүний эрх ба гэмт хэрэг” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан.





Зураг. Сургалтын явц

8. Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь Сүхбаатар дүүргийн прокурорын газартай хамтран ажиллах гэрээтэй болно. Хамтын ажиллагааны дагуу Прокурорын газрын хяналтын прокурор Б.Өнөбаттай хамтран Ерөнхий мэс заслын тасагт хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн үл тохирол дахин гарахаас урьдчилан сэргийлж 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Ерөнхий мэс заслын тасгийн нийт ажилтнуудад “Хүний эрх ба гэмт хэрэг” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явцаас

9. Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь Сүхбаатар дүүргийн прокурорын газартай хамтран ажиллах гэрээтэй болно. Прокурорын газрын хяналтын прокурор Б.Өнөбаттай хамтран Дүрс оношлогооны төвд үүссэн үл тохирол дахин

гарахаас урьдчилан сэргийлж 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Дүрс оношлогооны төвийн нийт ажилтнуудад “Хүний эрх ба гэмт хэрэг” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явцаас

10. 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн (лхагва гариг) өглөө 08.00 цагт эмнэлгийн 4-р давхрын хурлын их танхимд нийт эмч нарт Нийгмийн эрүүл мэндийн албаны сэтгэцийн эмч, сэтгэл засалч А.Оюунжаргал “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийг үнэлсэн байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Зураг. Сургалтын явцаас

11. Эрүүл мэндийн яам, Зэлэм тархи ТББ-тай хамтран Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 2025.05.08-2025.07.17-ны өдрийн хугацаанд 15 сэдвийн дагуу 7 нэгжийн 51 ажилтанд “Харилцаа хандлага, ёс зүй, зөөлөн ур чадвар болон Багаар ажиллах чадварын сургалт”-ыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж эхлээд байна. Сургалтын хөтөлбөрт тусгагдсан 15 удаа сэдвийн дагуу хичээлүүд орж байна.



Зураг. Цуврал сургалтын танилцуулга

Сургалтын хөтөлбөр

№	Сургалтын явуулах сэдэв	Улсын 1-р төв эмнэлэг	Байгууллага	Сургагч багш нарын мэдээлэл	
				Овог, нэр	Албан тушаал
1	Мартахуйн гайхамшиг	2025/05/08	"Зэлэм тархи" ТББ	М.Оюун-Эрдэнэ	Сургалтын албаны захирал, багш, көүч
2	Анхны эерэг сэтгэгдэл төрүүлэх нь	2025/05/15	Хүрээ амаржих газар	Б.Цэцэгмаа	Захиргаа, хүний нөөцийн хөгжлийн албаны дарга
3	Тогтвортой харилцаа ба итгэлцэл	2025/05/22	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	Х.Сарангэрэл	Сургалт хариуцсан менежер
4	Стрессээ эерэгээр удирдах энгийн арга	2025/05/29	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	Ж.Нармандах	Сувилахуй үйлчилгээний албаны дарга
5	Инээмсэглэлийн хүч	2025/06/05	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	Ц.Одонтуяа	Захиргаа, хүний нөөцийн албаны дарга
6	Алсын хараа-Амьдралын шугам	2025/06/12	Гернатолагийн үндэсний төв	М.Отгонжаргал	Ахлах сувилагч
7	Үе хоорондын онцлогыг ойлгох нь	2025/06/19	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	Ж.Нармандах	Сувилахуй үйлчилгээний албаны дарга
8	Багийн үнэ цэнэтэй гишүүн байх нь	2025/06/26	Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг	Б.Ариунцэцэг	Сургалт судалгаа, соёл үйлчилгээ,

					хамтын ажиллагааны албаны дарга
9	Багийн зөрчлийг удирдах нь	2025/07/03	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг	Б.Ариунцацрал	Үйлчлүүлэгчдийг дэмжих албаны дарга
10	Баг дотор сэтгэл хөдлөлийг ойлгох нь	2025/07/17	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	Х.Сарангэрэл	Сургалт хариуцсан менежер
11	SWOT үнэлгээний аргад суралцах нь	2025/07/24	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв	С.Буян-Орших	Сургалт хөгжил хамтын ажиллагааны албаны дарга
12	Багийн хурлыг үр дүнтэй удирдах арга	2025/08/01	Хүрээ амаржих газар	Б.Цэцэгмаа	Захиргаа, хүний нөөцийн хөгжлийн албаны дарга
13	Хязгааргүй сэтгэлгээ	2025/08/07	Гернатолийн үндэсний төв	М.Отгонжаргал	Ахлах сувилагч
14	Хялбараар ажил даалгах арга	2025/08/14	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Б.Сарангэрэл	Хүний нөөцийн мэргэжилтэн
15	Өөр хоорондоо харилцан адилгүй зан төлвийг удирдах	2025/08/19	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	Ц.Одонтуяа	Хүний нөөцийн албаны дарга

2025 оны 5 дугаар сард 4 хичээл амжилттай зохион байгуулагдсан байна. Үүнд: 2025.05.08-ны өдөр Мартахуйн гайхамшиг сэдэвт сургалтыг "Зэлэм тархи" ТББ-ын Сургалтын албаны захирал, багш, көүч М.Оюун-Эрдэнэтэй хамтран зохион байгуулсан.





Зураг. Сургалтын явцаас

12. Эрүүл мэндийн яам, Зэлэм тархи ТББ-тай хамтран Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 2025.05.08-2025.07.17-ны өдрийн хугацаанд 15 сэдвийн дагуу “Харилцаа хандлага, ёс зүй, зөөлөн ур чадвар болон Багаар ажиллах чадварын сургалт”-ын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хоёр дахь удаагийн сургалт 2025.05.15-ны өдөр “Анхны эерэг сэтгэгдэл төрүүлэх нь сэдэв”-ээр Хүрээ амаржих газрын Захиргаа, хүний нөөцийн хөгжлийн албаны дарга Б.Цэцэгмаатай хамтран зохион байгуулсан. УНТЭ-ийн 7 нэгжийн 51 ажилтан хамрагдсан.



Зураг. Сургалтын явцаас

13. Эрүүл мэндийн яам, Зэлэм тархи ТББ-тай хамтран Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 2025.05.08-2025.07.17-ны өдрийн хугацаанд 15 сэдвийн дагуу “Харилцаа хандлага, ёс зүй, зөөлөн ур чадвар болон Багаар ажиллах чадварын сургалт”-ын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байна. Хөтөлбөрийн гурав дахь удаагийн сургалт 2025.05.22-ны өдөр “Тогтвортой харилцаа ба итгэлцэл”-ээр Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв Сургалт хариуцсан менежер Х.Сарангэрэлтэй хамтран зохион байгуулсан. УНТЭ-ийн 7 нэгжийн 51 ажилтан хамрагдсан.



Зураг. Сургалтын явцаас

14. Эрүүл мэндийн яам, Зэлэм тархи ТББ-тай хамтран Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 2025.05.08-2025.07.17-ны өдрийн хугацаанд 15 сэдвийн дагуу “Харилцаа хандлага, ёс зүй, зөөлөн ур чадвар болон Багаар ажиллах чадварын сургалт”-ын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байна. Хөтөлбөрийн гурав дахь удаагийн сургалт 2025.05.29-ны өдөр “Стрессээ эерэгээг удирдах энгийн арга”-аар Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Сувилахуйн үйлчилгээний албаны дарга Ж.Нармандахтай хамтран зохион байгуулсан. УНТЭ-ийн 7 нэгжийн 51 ажилтан хамрагдсан.



Зураг. Сургалтын явцаас

15.2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Монголын сувилагчдын нийгэмлэг, Эрүүл мэндийн яамтай хамтран зохион байгуулсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ” сэдэвт 2 багц цагийн олон улсын сургалтад тус эмнэлгээс 5 ажилтанг хамруулсан. Үүнд:

- Сувилахуйн албаны арга зүйч Д.Долгор
- Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч Б.Гулжан
- Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч С.Түмэндэмбэрэл
- Яаралтай тусламжийн тасгийн сувилагч Г.Гэрэлсайхан
- Яаралтай тусламжийн тасгийн сувилагч Г.Анзаяа нарыг хамруулсан.



Зураг. Сургалтын явцаас

УНТЭ-ийн эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо
УНТЭ-ийн Захиргаа

2025.05.30